



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 349


Улаанбаатар хот

Г Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тудгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 56 дугаар зүйлийн 56.2.4, Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 9.1.6, Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чандмань андууд” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар тудгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй, тусгай зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй тохиолдолд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг “Чандмань андууд” ХЗХ /Б.Наранчимэг/-нд анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН